



# СПОРТЫН АРБИТРЧ

## НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

Монголын олон улсын ба үндэсний Спортын арбитр нь Олон улсын олимпын хорооноос ирсэн чиглэлийн дагуу 2017 оноос хойш МҮОХороо, Допингийн эсрэг үндэсний төв болон олимпын төрлийн болон олимпын бус, үндэсний спортын 70 орчим холбоод, байгууллагуудтай спорттой холбоотой гарсан хэрэг, маргааныг шийдвэрлүүлэхээр гэрээ, хэлцэл байгуулж хамтран ажиллаж байна. Спортын хэрэг маргааныг шийдвэрлэх Спортын арбитрч болон зөвхөн допингийн хэрэг маргааныг шийдвэрлэх арбитрч нарыг нээлттэй сонгон шалгаруулах зорилгоор энэхүү урилгыг гаргаж байна.

**Нэг.** Монгол Улсад спортын байгууллага, спорттой холбоотой маргааныг хараат бусаар, алагчлалгүй хэлэлцэн шийдвэрлэхээр спортын төрөлжсөн, байнгын ажиллагаатай арбитрыг Арбитрын тухай хуулийн 2.1, 2.2, 7.3, 8.1 дүгээр зүйл, Биеийн тамир, спортын тухай хуулийн 27.2 дугаар зүйл, Олимпын хартийн 61.1 дүгээр зүйлийг тус тус үндэслэн Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрыг 2017 оны 02 дүгээр сарын 07-ны өдөр үүсгэн байгуулсан болно.

**Хоёр.** Олон улсын олимпын хороо (ИОС)-оос 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Монгол улсад спортын хэрэг маргааныг шийдвэрлэх үйл ажиллагаа явуулах байгууллага байгуулсанд талархлаа илэрхийлэн хүлээн зөвшөөрсөн байдаг.

**Гурав.** Олон улсын спортын арбитрын шүүх (CAS)-ээс 2017 оны 05 дугаар сарын 3-ны өдөр “Танай улсад гарч буй спорттой холбоотой маргааныг шийдвэрлэх чадвартай үндэсний спортын шүүх байгуулах Монгол Улсын санаачилгыг CAS дэмжиж байна” хэмээн мэдэгдсэн болно.

**Дөрөв.** Биеийн тамир, спортын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт “Талууд гэрээнд маргааныг арбитраар шийдүүлэхээр харилцан тохиролцсон, шүүхийн харьяаллын бус бусад спортын үйл ажиллагаатай холбоотой маргааныг арбитрын журмаар шийдвэрлүүлнэ” гэж заасны дагуу Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

**Тав.** Засгийн газрын 2022.10.19-ны өдөр баталагдсан Допингийн эсрэг үндэсний дүрмээр допингтой холбоотой хэрэг, маргааныг үндэсний хэмжээнд эцэслэн шийдвэрлэхээр зохицуулсан.

## СПОРТЫН АРБИТРЧИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монголын олон улсын ба үндэсний Спортын арбитрын дүрмийн 3.1-т “Монголын олон улсын ба үндэсний Спортын арбитр, салбар арбитрын арбитрчид нь мэргэшсэн хуульч, спортын мэргэжил, цол зэрэг, дэвтэй тамирчин, спортын ажлын дадлага туршлагатай /багш, дасгалжуулагч, спортын шүүгч/, тухайн спортын төрлөөр нарийн мэргэшсэн, эрдэмтэн, багш байх ба ял шийтгэлгүй 30-аас дээш настай байх шалгуурыг хангасан гадаад, дотоодын иргэд нэр дэвшиж Холбооны Удирдах зөвлөлөөс 4 жилийн хугацаагаар сонгож, нэрсийн жагсаалтыг батлана” гэж заасны дагуу шаардлага хангасан Спортын арбитрчаар ажиллах чин хүсэл, эрмэлзэлтэй хувь хүнийг доорх материалыг бүрдүүлэн өгч нээлттэй сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна.

### Орон тоо:

Спортын арбитрч: 6 хүн

Спортын допингийн арбитрч: 5 хүн

### Бүрдүүлэх материал:

1. Спортын арбитрчаар эсхүл Спортын допингийн арбитрчаар элсэх гараар бичсэн хүсэлт
2. Монголын олон улсын ба үндэсний Спортын арбитрын Арбитрчын анкет
3. Цээж зураг – 2%

### Хүлээн авах газар:

Шуудангын хаяг: Сүхбаатар дүүрэг, Жамъян гүний гудамж, Даун таун барилга 1204 тоот

Имейл хаяг: info@sportarbitration.mn

### Холбогдох утас:

Нарийн бичгийн дарга: Г.Мишээлт 88263002

### Хүлээн авах хугацаа.

2023 оны 01 сарын 15-ны өдрийг хүртэл

---